



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алтай сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/01/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Ховд хот

2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор:

Утас:

Цахим хаяг:

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ӨХЗ	Өмч хамгаалах зөвлөл
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуун тооцоот үйлдвэрийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ГХУСЗЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл

Аудитын гол асуудал

Өмнөх онуудад төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг байсан Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын төвийн санхүүгийн тайлангийн тогтмол зардлаас бусад үзүүлэлтүүд системийн дээд байгууллагын тайланд нэгтгэгдэх бодлогын өөрчлөлт бий болсонтой холбоотойгоор эдийн засгийн гол үзүүлэлтүүдэд нөлөөлөл бүхий өөрчлөлтүүд орсон байна.

Бусад асуудлын хэсэг

Сумын ИТХ-ын 8/02 тогтоолоор Сумын засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг 88.8 буюу “Хангалттай” гэж үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЯДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мянган.төгрөгөөр

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,005,035.00	1,165,937.60
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	281,253.70	471,714.20
33	АВЛАГА	230,016.90	220,251.10
34	УРЬДЧИЛГАА	71,837.20	223,298.30
35	БАРАА МАТЕРИАЛ	421,927.30	250,674.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	10,797,491.00	3,861,859.60
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	10,631,298.80	3,861,859.60
39100	Газар	0	0
39200	Биет хөрөнгө	10,561,512.60	3,857,390.90
39300	Биет бус хөрөнгө	69,786.20	4,468.80
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	0	0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	11,636,333.80	5,027,797.20
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	36,085.50	0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	36,085.50	0
41300	Өглөг	36,085.50	0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	11,600,248.40	5,027,797.20
51	Засгийн газрын хувь оролцоо	11,600,248.40	5,027,797.20
51100	Засгийн газрын оруулсан капитал	4,099,020.20	1,034,383.70
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	0	0
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	4,099,020.20	1,034,383.70
51200	Хуримтлагдсан үр дүн	5,328,808.20	3,414,991.20
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,172,420.00	578,422.40
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	11,636,333.80	5,027,797.20

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

Мянган.төгрөгөөр

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,461,344.00	2,959,093.10
11	ТАТВАРЫН ОРЛОГО	183,762.90	427,667.80
110	Орлогын албан татвар	81,937.80	218,932.40
1100	Хувь хүний орлогын албан татвар	81,937.80	218,932.40
113	Хөрөнгийн албан татвар	25,490.30	34,216.50
118	Бусад татвар, төлбөр, хураамж	76,334.80	174,518.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	579,054.50	854,778.80
120	Нийтлэг татварын бус орлого	579,054.50	854,778.80
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,698,526.60	1,676,646.50
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,147,824.70	2,424,673.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,147,824.70	2,424,673.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,140,881.70	2,384,685.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,679,113.70	345,294.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	223,922.70	42,742.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	225,876.20	887,814.20

2104	Хангамж, бараа материалын зардал	353,933.60	561,328.40
2105	Нормативт зардал	199,770.50	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,080.30	6,683.50
2107	Томилолт, зочны зардал	6,094.20	5,679.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,834.90	30,851.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	409,255.40	504,292.40
211	ХҮҮ	0	0
212	ТАТААС	0	0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,006,943.10	39,987.50
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	313,519.30	534,419.80
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0	0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	997.2	7,389,477.20
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	312,522.00	-6,855,057.40

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

Мянган.төгрөгөөр

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,064,955.80	2,401,817.50
11	ТАТВАРЫН ОРЛОГО	183,762.90	427,667.80
110	Орлогын албан татвар	81,937.80	218,932.40
1100	Хувь хүний орлогын албан татвар	81,937.80	218,932.40
113	Хөрөнгийн албан татвар	25,490.30	34,216.50
118	Бусад татвар, төлбөр, хураамж	76,334.80	174,518.90
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	6,310.30	6,392.30
1181	Газрын төлбөр	631.5	6,830.40
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	69,393.00	161,296.30
1183	Бусад татвар	0	0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	203,576.10	313,695.40
120	Нийтлэг татварын бус орлого	203,576.10	313,695.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,677,616.80	1,660,454.30
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,641,867.60	1,492,283.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,641,867.60	1,492,283.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,599,278.00	1,451,592.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,719,809.80	364,657.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	219,567.80	45,132.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	230,033.40	891,748.60
2104	Хангамж, бараа материалын зардал	95,319.00	35,424.90
2105	Нормативт зардал	173,145.60	335.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,055.10	9,177.80
2107	Томилолт, зочны зардал	5,714.20	5,379.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44,462.10	47,216.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	92,171.00	52,520.70
211	ХҮҮ	0	0
212	ТАТААС	0	0

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,042,589.60	40,690.80
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	423,088.20	909,534.20
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0	0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	288,235.50	642,973.70
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	288,235.50	642,973.70
2200	Дотоод эх үүсвэрээр	288,235.50	642,973.70
2260	Гадаад эх үүсвэрээр	0	0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-288,235.50	-642,973.70
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-15,000.00	-76,100.00
14	Бусад эх үүсвэр	0	0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	15,000.00	76,100.00
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	0	0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	0	0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	119,852.70	190,460.50
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	161,401.00	281,253.70
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	281,253.70	471,714.20

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

Мянган.төгрөгөөр

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,303,549.30	11,303,549.30
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-15,823.00	-15,823.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,287,726.30	11,287,726.30
9	Тайлант үеийн үр дүн	312,522.00	312,522.00
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,600,248.40	11,600,248.40
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	11,600,248.40	11,600,248.40
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-140,549.90	-140,549.90
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,459,698.50	11,459,698.50
19	Тайлант үеийн үр дүн	-6,855,057.40	-6,855,057.40
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	5,027,797.20	5,027,797.20

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан

Мянган.төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	гүйцэтгэл	л зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,155,985.00	1,690,087.41	465,897.59
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,037,761.90	971,013.75	66,748.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	956,664.40	934,693.25	21,971.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	357,442.30	343,317.61	14,124.69
210101	Үндсэн цалин	240,424.30	237,475.13	2,949.17
210102	Нэмэгдэл	62,476.00	54,315.06	8,160.94
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	873.35	-873.35
210104	Урамшуулал	8,160.00	13,343.66	-5,183.66
210105	Гэрээт ажлын хөлс	46,382.00	37,310.41	9,071.59
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,455.90	42,797.33	1,658.57
210201	Тэтгэврийн даатгал	30,301.80	29,339.13	962.67
210202	Тэтгэмжийн даатгал	3,072.60	3,296.75	-224.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,238.90	2,814.17	424.73
210204	Ажилгүйдлийн даатгал	712.90	675.72	37.18
210205	Эрүүл мэндийн даатгал	7,129.70	6,671.55	458.15
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	438,560.30	434,476.97	4,083.33
210301	Гэрэл, цахилгаан	21,058.00	18,985.59	2,072.41
210302	Түлш, халаалт	390,812.90	388,802.68	2,010.22
210303	Цэвэр, бохир ус	26,689.40	26,688.70	0.70
210304	Байрны түрээс	0.00	0.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,583.30	25,574.60	8.70
210401	Бичиг хэрэг	3,997.80	3,942.50	55.30
210402	Тээвэр, шатахуун	18,096.80	18,152.10	-55.30
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,488.70	3,480.00	8.70
2105	Нормативт зардал	335.30	335.30	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	335.30	335.30	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,458.80	6,399.60	59.20
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	167.00	167.00	0.00
210604	Урсгал засвар	6,291.80	6,232.60	59.20
2107	Томилолт, зочны зардал	5,079.70	5,079.00	0.70
210701	Гадаад албан томилолт	0.00	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт	5,079.70	5,079.00	0.70
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.00	0.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,931.00	27,312.10	618.90
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,678.00	26,129.60	548.40
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	330.00	260.00	70.00
210803	Даатгалын үйлчилгээ	145.00	145.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	175.00	174.50	0.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,817.80	49,400.74	1,417.06
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	49,267.80	47,850.74	1,417.06
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,550.00	1,550.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	81,097.50	36,320.50	44,777.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	44,750.00	0.00	44,750.00

213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	44,750.00	0.00	44,750.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	0.00	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,347.50	36,320.50	27.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	25,817.50	25,817.50	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,530.00	10,503.00	27.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,018,223.10	642,973.66	375,249.44
220001	Барилга байгууламж	509,530.00	397,954.39	111,575.61
221001	Их засвар	231,533.70	88,706.87	142,826.83
222001	Тоног төхөөрөмж	51,200.00	62,328.70	-11,128.70
223001	Бусад хөрөнгө	225,959.40	93,983.70	131,975.70
224001	Стратегийн нөөц хөрөнгө	0.00	0.00	0.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	100,000.00	76,100.00	23,900.00
230001	Эргэж төлөгдөх зээл	100,000.00	76,100.00	23,900.00
231001	Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих зээл	0.00	0.00	0.00
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	0.00	0.00	0.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,155,985.00	1,929,968.32	226,016.68
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,693,375.40	1,655,539.27	37,836.13
320001	Орон нутгийн төсвөөс	1,060,906.90	1,023,070.77	37,836.13
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	632,468.50	632,468.50	0.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	462,609.60	274,429.05	188,180.55
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,405.00	4,100.00	305.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	278,183.40	270,329.05	7,854.35
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	180,021.20	0.00	180,021.20
350004	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	0.00	0.00	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	157,990.87	-157,990.87
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	397,371.90	-397,371.90

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан

Мянган.төгрөгөөр

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	520,201.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	520,201.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	488,084.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,922.50
210101	Үндсэн цалин	1,922.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	454,033.44
210301	Гэрэл, цахилгаан	916.17
210302	Түлш, халаалт	453,117.27
2104	Хангамж, бараа материалын зардал	7,135.70
210401	Бичиг хэрэг	1,320.00
210402	Тээвэр, шатахуун	5,815.70

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,778.20
210604	Урсгал засвар	2,778.20
2107	Томилолт, зочны зардал	300.00
210702	Дотоод албан томилолт	300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,865.07
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,865.07
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,050.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,050.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,116.45
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,850.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,850.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	28,266.45
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	20.39
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	28,246.06
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	520,180.98
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	520,180.98
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	116,609.07
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	350,182.31
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	53,389.60
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-20.39
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	20.39

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Алтай сумын Засаг дарга нь Монгол улсын Үндсэн хууль болон УИХ, Засгийн газраас гарч буй хууль тогтоомжид нийцүүлэн “Орон нутгийн хөгжил дэвшилд манлайлагч байж мэдлэг чадварт суурилсан нутгийн захиргааны мэргэшсэн байгууллага байх” эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон дараах зорилтыг тавин ажилласан байна. Үүнд:

- ✓ Хууль тогтоомж, хөгжлийн бодлого, стратеги зорилт, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохин байгуулж хяналт тавих
- ✓ Баг байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулж, мэргэшил арга зүйн удирдлагаар хангах
- ✓ Хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохин байгуулах
- ✓ Тамгын газрын үйл ажиллагааг удирдан зохин байгуулах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах тайлагнах, хяналт тавих
- ✓ Хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг
- ✓ Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, цахим систем нэвтрүүлж, иргэдийн цаг хугацаа зардлыг хэмнэх
- ✓ Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ,
- ✓ Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль,

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль зэрэг хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд 2022 онд нэмэлт өөрчлөлтүүд орсон байна. 2022 онд нь Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд 4 удаа, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд 1 удаа, Төсвийн тухай хуульд 6 удаа, Шилэн дансны тухай хуульд 1 удаагийн өөрчлөлт орж Төрийн хэмнэлтийн тухай хууль шинээр батлагдан мөрдөгдөж эхэлсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2021 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 22-р тогтоолоор байгуулагдсан сумын өмч хамгаалах байнгын зөвлөл тус сумын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавин ажиллаж төсвийн хөрөнгөөр болон хандив тусламжаар ирсэн хөрөнгөд хяналт тавин ИТХ-ын хуралдаанаар тогтоол гаргуулан өмч хөрөнгийг бүртгэлд тусгуулж, актлах хөрөнгийг шийдвэрийн дагуу устгах ажлыг хариуцан ажиллаж жилийн ажлыг 92.3 хувьтай дүгнүүлсэн байна.

Алтай сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алтай сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сумын нэгтгэсэн санхүүгийн тайланд мөрдөх тусгайлан баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй бөгөөд Сангийн яамнаас гаргасан бодлого шийдвэрүүдийг хэрэгжүүлэн и-баланс цахим программ хангамж ашиглан холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн, үйл ажиллагааны онцлогт тохируулан ашиглаж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Алтай сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6848.5 сая төгрөгөөр буюу 40 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өөрчлөлт	
Мөнгөн хөрөнгө	281.3	471.7	-190.4	1.7
Авлага	230.0	220.2	9.8	1.0
Урьдчилгаа	71.8	223.3	-151.5	3.1
Бараа материал	421.9	250.7	171.2	0.6
Үндсэн хөрөнгө	10631.3	3861.8	6,769.5	0.4
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	11636.3	5027.7	6,608.6	0.4
Богино хугацаат өр төлбөр	36.1	0	36.1	0.0
Цэвэр хөрөнгө, өмч	11600.2	5027.8	6,572.4	0.4
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	11636.3	5027.8	6,608.5	0.4

Эх сурвалж: Алтай сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад, санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлттэй мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, үндсэн хөрөнгө цэвэр өмч хөрөнгийн данснууд байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 281.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 471.7 сая төгрөг болж 190.4 сая төгрөгөөр буюу 68 хувиар өссөн байна. ОНХС-ийн төлөвлөсөн ажлууд он дамжин хэрэгжиж байгаатай холбогдон ажлын үлдэгдэл санхүүжилтийн үлдэгдэлээс өссөн байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 220.2 сая төгрөг болж, өмнөх оноос 9.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр	
			Өсөлт (+), Бууралт (-)	
Байгууллагаас авах авлага	55.1	-	(55.1)	
Хувь хүмүүсээс авах авлага	174.9	220.2	45.3	
Дүн	230.0	220.2	(9.8)	

Эх сурвалж: Алтай сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага 9.8 сая төгрөгөөр буурсан нь хоршоо хөгжүүлэх сангаас 76.0 сая төгрөгийн зээл олгосон ба 30.3 сая төгрөгийн зээлийн авлагыг барагдуулсан, Улсын төсвийн байгууллагуудын балансыг шилжүүлсэнтэй холбоотой Ерөнхий боловсролын сургуулийн балансад бүртгэлтэй 13.0 сая төгрөгийн авлага, татаас санхүүжилтийн авлага 3.4 сая төгрөгийн авлага, Эрүүл мэндийн төвийн балансад бүртгэлтэй татаас санхүүжилтийн авлага мөн байгууллагаас авах авлага 37.4 сая төгрөгийн авлага, шилжиж барагдуулсантай холбоотой өөрчлөгдсөн байна.

3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 223.3 сая төгрөг болж, өмнөх оноос 151.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Урьдчилгаа дансны үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	71.8	223.3	151.5
Тусгай зориулалтын сан			-
Дүн	71.8	223.3	151.5

Эх сурвалж: Алтай сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нээлтгэсэн тайлан

Алтай сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгааны эхний үлдэгдэл 71.8 сая төгрөгөөс тайлант онд 61.1 сая төгрөгийн авлагыг барагдуулж 212.5 сая төгрөгийн 5 ажлын санхүүжилтийг олгож, он дамжсан хэрэгжээгүй 1 ажлын хөрөнгө хүлээн аваагүйтэй холбоотой авлагаар бүртгэсэнтэй холбоотой байна.

3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 250.67 сая төгрөг болж 171.3 сая төгрөгөөр буурсан байна.

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	
Түүхий эд материал	24.702	0	24.7	0.0
Тусгай зориулалттай материал	0	0.00	0.0	0.0
Эм боох материал	24.702	0.00	24.7	0.0
Бэлэн бүтээгдэхүүн	0	0.00	0.0	0.0
Хангамжийн материал	397.224	250.671	146.6	0.0
Бичиг хэргийн материал	7.440	0.57	6.9	0.1
Аж ахуйн материал	116.343	32.52	83.8	0.3
сэлбэг хэрэгсэл	0	0.00	0.0	0.0
Түлш шатах тослох материал	0.213	0.00	0.2	0.0
Барилгын засварын материал	3.810	0.00	3.8	0.0
Хүнсний материал	14.337	0.00	14.3	0.0
Бусад хангамжийн материал	48.492	15.530	33.0	0.3
Мал амьтад	206.589	202.054	4.5	1.0
Нөөцийн бараа	0	0.00	0.0	1.0
Нийт бараа материал	421.926	250.67	171.3	0.6

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 88.2 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, аймгаас буцаан олгох нөхцөлтэйгээр 10.0 сая төгрөгийн өвс тэжээлийн нөөц бүрдүүлж, 80.9 сая төгрөгийн материалыг зарцуулж, 178.4 сая төгрөгийн бараа материалыг улсын төсвийн байгууллагуудын балансаас балансад шилжүүлсэнтэй холбоотой өөрчлөлт орсон байна.

3.4.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 12569.9 сая төгрөг байсан бол оны эцэст 4747.3 сая төгрөг болж 7822.6 сая төгрөгөөр буурсан нь Засаг даргын тамгын газрын балансад бүртгэлтэй Алтай Шим-ус ОНӨААТҮГ-ын 395.4 сая төгрөгийн цэвэр усны байгууламжийг Ховд аймгийн Шим ус ОНӨААТҮГ-луу, улсын төсвийн байгууллагуудын 7808.4 сая төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлж төсвийн хөрөнгөөр 3.3 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 8 ажлын өртөг 345.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, 4 багийн засаг дарга нарт өөрийн болон засгийн хөрөнгийн оролцоотой 4 ширхэг 13.2 сая төгрөгийн мотоцикл гэх мэт хөрөнгүүдийг орлогод авч, 160.2 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой буурсан байна.

3.4.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 36.1 сая, эцсийн үлдэгдэл 0 сая төгрөг болж 36.1 сая төгрөгөөр буурсан байна. Балансаас балансад 36.1 сая төгрөгийн өглөг шилжүүлсэнтэй холбоотой байна.

3.4.7 Цэвэр хөрөнгө, өмч

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 4099.0 сая төгрөг байснаас оны эцэст 1034.4 сая төгрөг болж 3064.6 сая төгрөгөөр буурсан нь Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын төвийн баланс шилжсэнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2382.7 сая төгрөгөөр, нийт зарлагыг 2382.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нэгтгэсэн төсвийг аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 04 өдрийн 5/07 тоот тогтоолоор 1669.7 сая төгрөгөөр анх баталж ирснийг сум ИТХ-ын 2021 оны 12 сарын 17-ны 4/05 тогтоолоор 2155.8 сая төгрөгөөр баталсан. Өмнө оны болон тайлант оны давсан орлоготой холбоотойгоор аймаг 2022 онд 1 удаа тодотгол хийн 2022 оны 06 дугаар сарын 10-ны 7/02 тоот тогтоолоор нийт 2143.7 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголыг сумын ИТХ-аар 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 6/02 тоот тогтоолоор 2155.9 сая төгрөгөөр тодотгож баталжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 2155.9 сая төгрөгийн төсөв баталснаас 502.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 500.1 сая төгрөг татварын болон татварын бус орлогоос, 632.5 сая төгрөгийг ОНХС-аас санхүүжих, 4.4 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 278.2 сая төгрөгийг туслах үйл ажиллагаанаас, 238,3 сая төгрөгийг өмнөх оны үлдэгдлээс санхүүжүүлжээ.

Хүснэгт 5. Татварын болон татварын бус орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл сая төгрөгөөр

Санхүүжилтийн эх үүсвэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Татварын болон татварын бус орлого	504.5	443.5
Татварын орлого	491.3	427.7

Татварын бус орлого	13.2	15.8
Орон нутгийн төсвөөс санхүүжих	1135.0	1156.5
Орон нутгийн төсвөөс	502.5	524.0
Орон нутгийн хөгжлийн сан	632.5	632.5
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	516.5	508.6
Туслах үйл ажиллагааны орлогоос	278.2	270.3
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	238.3	238.3
ЭХ ҮҮСВЭРИЙН НИЙТ ДҮН	2156.0	2108.6

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 524.0, орон нутгийн татварын болон татварын бус орлого 443.5, ОНХС-ийн санхүүжилт 632.5, үндсэн үйл ажиллагааны орлогоос 4.1, туслах үйл ажиллагааны орлого буюу сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, хамтын гэрээний орлогоос 270.3, урьд оны үлдэгдлээс 238.3 сая төгрөгийг тус тус зарцуулах эрх нээлгэж нийт 2108.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1690.1 сая төгрөгийг зарцуулж 418.5 сая төгрөгийн үлдэгдэлтэйгээс ОНХС-д зарцуулагдаагүй үлдсэн үлдэгдэл 381.3 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх санд 16.0 сая төгрөг, 46.1 сая төгрөг орон нутгийн ерөнхий орлогод төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1690.1 сая төгрөг буюу 78.4 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 15.9 сая, Бараа үйлчилгээний бусад зардал 1.4 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлыг 0.6 сая, байр ашиглахтай холбоотой тогтмол зардал 3.8 сая, Хоршоо хөгжүүлэх сангаас 9 иргэнд 76.0 сая төгрөгийн зээл олгосон, нийт 21.7 сая төгрөгөөр батлагдсан төсвийг хэмнэж зарцуулсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг 4.4, туслах үйл ажиллагааны орлого 278.2 сая төгрөгөөр тус тус батлагдаж гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлогыг 4.1 сая, туслах үйл ажиллагааны орлогоос сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс 30.3 сая, хамтын гэрээний өөрийн орлого 240.0 сая нийт 270.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж 7.9 сая төгрөгөөр туслах үйл ажиллагааны орлого буюу зээлийн эргэн төлөлтийн орлого тасарсан байна.

Хүснэгт 6. Сумын татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая.төгрөг/

Орлогын ангилал	2022 оны		Зөрүү
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Татварын нийт орлогын дүн	504.50	443.45	61.1
Нийт орлого ба тусламжийн дүн	491.30	427.66	63.6
Татварын орлого	491.30	427.66	63.6
Орлогын албан татвар	170.16	167.56	2.6
Хувь хүний орлогын албан татвар	170.16	167.56	2.60
Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын	123.86	150.46	(26.6)
Үйл ажиллагааны орлого	25.00	11.99	13.0
Шууд бус орлого	21.30	5.11	16.2
Хөрөнгийн албан татвар	119.75	85.58	34.2
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	1.50	4.45	(2.9)
Бууны албан татвар	3.25	3.44	(0.2)
Малын тоо толгойн албан татвар	65.00	26.33	38.7
Иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого	50.00	51.37	(1.4)
Бусад татвар, төлбөр, хураамж	201.39	174.52	26.9
Бусад нийтлэг төлбөр, хураамж	9.50	6.39	3.1
Улсын тэмдэгийн хураамж	2.50	3.84	(1.3)

Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны	2.50	0.36	2.1
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	4.50	2.20	2.3
Газрын төлбөр	1.34	6.83	(5.5)
Газрын төлбөр	1.34	1.50	(0.2)
Дуудлага худалдаа	-	5.33	(5.3)
Байгалийн нөөц ашигласны төлбөр	190.55	161.30	29.3
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	179.55	157.70	21.9
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	1.00	0.45	0.5
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	10.00	3.14	6.9
Татварын бус орлого	13.20	15.79	(2.6)
Нийтлэг татварын бус орлого	13.20	15.79	(2.6)
Хувьцааны ногдол ашиг	-	-	-
Торгуулийн орлого	8.80	11.69	(2.9)
Төсөвт байгууллагын өөрийн орлого	4.40	4.10	0.3

Эх сурвалж: Алтай сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт орлого 427.7 сая төгрөг орж 63.6 сая төгрөгөөр тасарч биелсэн байна. Татварын орлогын гүйцэтгэлийг нэр төрлөөр нь авч үзвэл цалин хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 26.6 сая төгрөг, үл хөдлөх хөрөнгийн татвар 2.9 сая төгрөг, бууны албан татвар 0.2 сая, иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого 1.4 сая, улсын тэмдэгтийн хураамж 1.3 сая, газрын төлбөр 0.2 сая, газрын дуудлага худалдаа 5.3 сая төгрөгөөр тус тус орлого давж, ан амьтан нөөц ашигласны төлбөр 21.8 сая төгрөг, хог хаягдлын үйлчилгээний хураамж 2.3 сая, байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр 6.9 сая, түгээмэл тархацтай ашигт малтмалын орлого 2.1 сая, хувь хүний орлогын албан тавар 16.2 сая, үйл ажиллагааны орлого 13.0 сая, малын тоо толгойн албан татвар 38.7 сая, ус рашаан ашигласны төлбөр 0.5 сая төгрөгөөр тус тус тасалжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн тайлангаар ЗДТГ-ын нэмэлт дансаар аймгийн Засаг даргын А/407 захирамжаар 2021 оны төсөвт байгууллагуудын халаалтын өр шүүхийн шийдвэрээр 453.1 сая, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 10 сая төгрөг, Авто худаг-аас 5.7 сая төгрөг, ОНХС-ийн 2021, 2022 оны барьцаа хөрөнгө 14.6 сая, цахим өндрийн орлого 1.7 сая, төсвийн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого 23,1 сая, Байгаль орчин нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгө 6.9, статистикийн хэлтсээс 1.0 сая төгрөг, ИТХ-аас хүүхэд хамгааллын багт 0.3 сая, шүлхийн дархлаажуулалтын зардал 3.3, ЗДНХ-өөс 0.2 сая төгрөг нийт 519.9 сая төгрөг, ИТХ-ын нэмэлт дансаар 2021 оны жилийн эцэст төвлөрүүлсэн үлдэгдэл 0.3 сая төгрөг нийт 520.2 сая төгрөгийг төвлөрүүлэн бичиг хэрэг, тээвэр шатахуун, түлш халаалт, дотоод албан томилолт, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд тус тус тайлагнан үйл ажиллагаандаа зарцуулсан ба үлдэгдэл 28.2 сая төгрөгийг төрийн сангийн татан төвлөрүүлэлтийн дансанд төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, санхүү нягтлан бодох бүртгэл, хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аудитор У.Батчимэг 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрөөс 03 дугаар сарын 25-ний хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 03-ний өдрийн 1/48 албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,424.7 сая төгрөгөөс 2 хувиар буюу 48.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдал тооцох хувийг 80 хувиар буюу 38.7 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор ЗДТГ-нь байгууллагын төсвөөс хандив тусламж шагнал олгосон зөрчил илэрсэн тул зөрчлийг таслан зогсоох зөвлөмж өглөө.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тендерт шалгарсан оролцогчийн мэдээлэл, ЗДТГ, ИТХ, Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлсэн таван сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээг бүрэн мэдээлсэн бөгөөд төсөв өмч хөрөнгө зарцуулахтай холбоотой шийдвэрийн мэдээллийг мэдээлээгүйг аудитын явцад залруулан цахим системд мэдээлүүлээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар өгөгдсөн 1.9 сая төгрөгийн 2 төлбөрийн акт барагдаж 130.9 сая төгрөгийн 1 албан шаардлага 90.3 сая төгрөгийн 9 зөвлөмж өгөгдсөнийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 7. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		/сая төгрөгөөр/ Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	1.9	2	1.9	-	-	100.0
Албан шаардлага	1	130.9	1	90.3	-	40.6	69.0
Зөвлөмж	9	64.5	9	64.5	-	-	100.0
Нийт дүн	12	197.3	12	156.7	-	40.6	89.7

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Орон нутгийн хөгжлийн сангийн урьдчилж гарсан зардлаар бүртгэгдсэн хөрөнгө оруулалтын ажлуудын гүйцэтгэлүүдийг дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 635.4 сая төгрөгийн алдаа¹ илэрсэн тул Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтын дагуу санхүүгийн тайланд залрууллаа. Үүнд:

- Сумын ЗДТГ-т Аймгийн ИТХ-аас тогтоолоор орлого авах хөрөнгийг бүртгээгүйтэй холбоотой 635.4 сая төгрөгийн залруулга санхүүгийн тайланд хийж аймгийн нэгтгэлд авлаа.

Аудитаар нийт 34.1 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 10.7 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 23.4 сая төгрөгийн 4 зөвлөмж өглөө.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.1 Төлбөрийн акт

- ✓ ОНХС-гаас өмнө онд олгосон Цонжийн цагаан усанд нарны цахилгаан эх үүсвэртэй худаг гаргах ажлыг гүйцэтгээгүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" 5 дугаар зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

5.2 Зөвлөмж

5.2.1 Хоршоо хөгжүүлэх сангийн зээлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Хоршоо хөгжүүлэх сангаас 9 иргэнд 76.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон боловч барьцаа хөрөнгийн үнэлгээний жагсаалт, барьцаалсан үнэ, барьцаалсан эд хөрөнгийн гэрчилгээний эх хувь болон барьцаа хөрөнгийн улсын бүртгэлд бүртгүүлж барьцаалбар үйлдсэн тухай баримт байхгүй байгаагаас дүгнэхэд удирдлагын зүгээс тавих хяналт сул тухайн зээлүүдийг эргэн төлөгдөхгүй байх эрсдэлд оруулж байгаа зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төсвийн тухайн хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.7-д "41.2.7.хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах."Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаал А/361 тоот тушаалын заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Олгосон зээлүүдийн барьцаалсан эд хөрөнгийн гэрчилгээний эх хувь болон барьцаа хөрөнгийн улсын бүртгэлд бүртгүүлэн ажиллах

5.2.2 Цалин хөдөлмөрийн хөлстэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Төрийн албан хаагчдын ажлын үр дүнг улирал бүр дүгнэн ажиллаагүй зөрчил нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно", Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 2.1 Хуульд өөрөөр заагаагүй бол улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргээ хангалттай гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй албан хаагчид олгоно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн албан хаагчийн үр дүнгийн урамшууллыг улирлаар тооцон холбогдох хууль журамд нийцүүлэн батлагдсан төсөвт багтаан олгох

5.2.3 Орлогын бүрдүүлэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Нийт орлого 427.7 сая төгрөг орж 63.6 сая төгрөгөөр тасарч биелсэн байна. Ангийн орлогыг оновчтой төлөвлөөгүйгээс аймгийн төсвөөс 21.8 сая төгрөгийг нэмж санхүүгийн дэмжлэгээр олгосон байна. Татварын орлогын гүйцэтгэлийг нэр төрлөөр нь авч үзвэл ан, амьтан нөөц ашигласны төлбөр 21.8 сая төгрөг, хог хаягдлын үйлчилгээний хураамж 2.3 сая, байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр 6.9 сая, түгээмэл тархацтай ашигт малтмалын орлого 2.1 сая, хувь хүний орлогын албан тавар 16.2 сая, үйл

ажиллагааны орлого 13.0 сая, малын тоо толгойн албан татвар 38.7 сая, ус рашаан ашигласны төлбөр 0.5 сая төгрөгөөр тус тус тасалжээ.

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн орлогыг оновчтой төлөвлөн орлогыг нэр төрлөөр нь бүрэн биелүүлэн ажиллах

5.2.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Илрүүлэлт: ЗДТГ-ын засаг даргын нөөц хөрөнгөнөөс Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зөрчин хандив тусламжид 1.6 сая төгрөгийн олгосон байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3.хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгохыг хориглох заалтын хэрэгжилт хангагдаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн хуулийг мөрдөж ажиллах, Төсвөөс хандив тусламж олгохыг таслан зогсоох

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс Залруулсан		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийг ЗДТГ дутуу бүртгэсэн	1.0	635.4	1.0	635.4			1.0	635.4	-	-
Дүн	1.0	635.4	1.0	635.4	-	-	1.0	635.4	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Үүнээс					
	Нийт алдаа		Төлбөрийн акт		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хоршоо хөгжүүлэх сангийн журмыг баримталж олгосон зээлд УБХ-т барьцаалбар хийхгүйгээр зээл олгосон,	1	-			1	-
ОНХС-гаас өмнө онд олгосон Цонжийн цагаан усанд нарны цахилгаан эх үүсвэртэй худаг гаргах ажлыг гүйцэтгээгүй	1	10.7	1	10.7		

Нийт орлого 427.7 сая төгрөг орж 63.6 сая төгрөгөөр тасарч биелсэн байна. Ангийн орлогыг оновчтой төлөвлөөгүйгээс аймгийн төсвөөс 21.8 сая төгрөгийг нэмж санхүүгийн дэмжлэгээр олгосон байн	1	21.8			1	21.8
Төрийн албан хаагчдын ажлын үр дүнг улирал бүр үнэлж дүгнээгүй	1	-			1	
Дүн	4	32.5	1	10.7	3	21.8

Санхүүгийн тайлангийн аудитын илэрсэн нийцлийн аудитын зөрчлийн нэгтгэл
/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчин хандив тусламж олгосон	1.0	1.6	-	-	-	-	1.0	1.6
Дүн	1.0	1.6	-	-	-	-	1.0	1.6


АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:  А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР:


84770662
9066454

У.БАТЧИМЭГ



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2023 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/2171039

Ховд

ХОА-2022/01/НА-СТА-ТТЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ховд аймгийн Алтай сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар ОНХС-ын хөрөнгө оруулалтаар ОНХС-ийн хөрөнгөөр 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр дугаар №ХОААСДТГ/2020-18 тоот гэрээгээр Цонжийн цагаан усанд нарны цахилгаан үүсгүүртэй худаг шинээр гаргах ажлын урьдчилгаа санхүүжилт 9381.4 мянган төгрөг, өмнөх оны авлага 1106.8 мянган төгрөг нийт 10488.2 мянган төгрөгийн авлага он дамжин данс бүртгэлд тусгасан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" 5 дугаар зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" ОНХС-н журмын 3.3.7.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авах гэрээг холбогдох хууль, аргачлал, журамд нийцүүлэн хийх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих; гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно." Монгол Улсын Ерөнхий аудиторовын 202 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дээр дурдсан 10488222 /Арван сая дөрвөн зуун наян найман мянга хоёр зуун хорин хоёр мянган / төгрөгийг хариуцагч аж ахуйн нэгжээр төлүүлэн Алтай сумын Төрийн сан банкин дахь ОНХС-ийн 100160152400 тоот дансанд 2023 оны 5 дүгээр сарын 20-ны дотор төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2023 оны 6 дугаар сарын 10-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэхийг Засаг дарга Х.Түмэндэлгэр, Санхүү албаны дарга С.Нэмэхжаргал нарт нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Х.Болдбаатар*

АУДИТОР

У.БАТЧИМЭГ

¹ Монгол улс, Ховд аймаг, Цамбагарав баг, ЗДТГ-ын 3 давхар, Утас: 70433061, 70432545